



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 09 дүгээр сарын 06
№ 33 /942/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1814

Монгол Улсын
хууль

1815

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1821

Эрүүгийн хуульд өөрчлөлт
оруулах тухай

Зөрчлийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай

Яамдын зохион байгуулалтын
бүтэц, орон тооны хязгаар
батлах тухай

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

617.	Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай	1814
618.	Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1814
619.	Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1815
620.	Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1815

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

621.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг буцаах тухай	Дугаар 26	1816
622.	Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай	Дугаар 27	1816
623.	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай	Дугаар 28	1817
624.	Юмжаагийн Цэдэнбал агсны алдар гавьяаг мөнхжүүлж, түүний мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 29	1818
625.	Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 16 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 30	1819
626.	Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай	Дугаар 31	1819
627.	Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 07 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 32	1820

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

628.	Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 124	1821
------	---	------------	------

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

629.	Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай	Дугаар 3	1821
------	---	----------	------



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 30.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “2016 оны 09 дүгээр сарын 01-ний” гэснийг “2017 оны 07 дугаар сарын 01-ний” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4 дүгээр зүйл.Энэ хуулийн 1, 2, 3 дугаар зүйлд заасан ажиллагааг 2017 оны 10 дугаар сарын 01-ний дотор багтаан хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл.2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 2, 3, 5 дугаар зүйлийн “2016 оны 09 дүгээр сарын 01-ний” гэснийг “2017 оны 07 дугаар сарын 01-ний” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр баталсан Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “2016 оны 09 дүгээр сарын 01-ний” гэснийг “2017 оны 07 дугаар сарын 01-ний” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ БОЛОН ЭДИЙН БУС ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсгийн “2016 оны 9 дүгээр сарын 01-ний” гэснийг “2017 оны 03 дугаар сарын 01-ний” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 26

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ, ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ, ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ, ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИУДЫГ БУЦААХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу Улсын Их Хурал эцсийн найруулгатай танилцах, ёсчлох, Монгол Улсын Ерөнхийлөгчид илгээх, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд хэвлэн нийтлэх ажиллагаанууд хийгдээгүй тул Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Хууль сахиулах ажиллагааны тухай хууль, 2016 оны 05 дугаар сарын 19-ний өдөр баталсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/, 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдөр баталсан Прокурорын байгууллагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хууль санаачлагчид нь буцаасугай.

2.Энэ тогтоолыг 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

*/Энэ тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч 2016 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр
бүхэлд нь хориг тавьсан./*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ

Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд Сонгуулийн ерөнхий хороогоор дамжуулан санхүүжигдэх зардлын хэмжээг 13,904,601,571.0 /арван гурван тэрбум есөн зуун дөрвөн сая зургаан зуун нэг мянга таван зуун далан нэг/ төгрөг байхаар тогтоосугай.



2.Энэ тогтоолын 1-д заасан зардлыг дараахь байдлаар Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт нэгтгэн төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасгай:

1/Сонгуулийн ерөнхий хорооны батлагдсан төсвөөс 6,6 тэрбум төгрөгийг;

2/Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн батлагдсан зардлаас хэмнэгдсэн төсвөөс 1,5 тэрбум төгрөгийг;

3/Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахаар аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуваарилсан зардлаас 5.8 тэрбум төгрөгийг.

3.Энэхүү зардлыг Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт заасны дагуу зарцуулахыг Сонгуулийн ерөнхий хороо /Ч.Содномцэрэн/-нд зөвшөөрсүгэй.

4.Энэ тогтоолыг 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2016 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ТЕХНИК ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг тус тус хэрэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот

ЮМЖААГИЙН ЦЭДЭНБАЛ АГСНЫ АЛДАР ГАВЬЯАГ МӨНХЖҮҮЛЖ, ТҮҮНИЙ МЭНДЭЛСНИЙ 100 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Сайд нарын зөвлөлийн дарга асан, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар, БНМАУ-ын Маршал Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 100 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан түүний амьдрал, бүтээлийн талаархи түүхэн үнэнийг тайлбарлан таниулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Юмжаагийн Цэдэнбал агсны мэндэлсний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай:

1/Юмжаагийн Цэдэнбал агсны амьдрал, үйл ажиллагааны талаархи түүхэн үнэнийг ард түмэнд тайлбарлан таниулж, алдар гавьяаг нь мөнхжүүлэх арга хэмжээ авах;

2/ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг баталж, зохион байгуулах комисс байгуулан ажиллуулах;

3/Юмжаагийн Цэдэнбал агсны музей байгуулах арга хэмжээ авч, төрөөс түүнд болон эхнэрт нь олгосон шагнал, бэлэг дурсгал, эдэлж хэрэглэж байсан зүйлсийг уг музейд байрлуулах;

4/ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд судалж шийдвэрлэх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар
хот

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН 2015 ОНЫ 16 ДУГААР ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.8 дахь заалтад “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах.”, 44 дүгээр зүйлийн 44.3.7 дахь заалтад “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт гомдол гаргах.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах, ... эрхтэй.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;” гэснийг тус тус зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 16 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт “... Барьцаалагч бусад үүрэг гүйцэтгүүлэгчдийн төлбөрийг



барагдуулах үүрэг хүлээнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, ... эрхтэй ...” гэснийг зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар
хот

**Үндсэн хуулийн цэцийн 2016 оны
07 дугаар дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан “Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “... 281 дүгээр зүйлийн 281.3 дахь хэсэгт “Зээлийн гэрээ нь хариу төлбөргүй байна.” гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй ...”, гэснийг, 2 дугаар зүйлд “Иргэний хуулийн 282 дугаар зүйл, 283 дугаар зүйлийн 283.2, 283.3, 283.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байна” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2016 оны 08 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 124

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тул Дамдинсүрэнгийн Дамдин-Одыг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Гомбын Лхагвамааг Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Гун-Аагийн Сүрэнг Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Барьнын Сарантуяаг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Жигжидсүрэнгийн Сэлэнгийг Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Бэгзийн Аминчимэгийг Говьсүмбэр аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Чимэдрэгзэнгийн Оюунцэцэгийг Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Довжилжамцын Энхтуяаг Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Гомбын Адъяаатогтох, Намсрайн Гачмаа нарыг Өвөрхангай аймгийн Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 7 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 3

Улаанбаатар
хот

ЯАМДЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААР БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Яамдын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:



а/ Байгаль орчин, аялал жуулчлалын яам:

1. Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар (цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэстэй);
2. Төрийн захиргааны удирдлагын газар (уур амьсгалын өөрчлөлт, гадаад хамтын ажиллагааны хэлтэс, хуулийн хэлтэс, санхүүгийн хэлтэстэй);
3. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар (байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтэс, ой, ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтэстэй);
4. Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар;
5. Ойн бодлого зохицуулалтын газар;
6. Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар (усны нөөцийн хэлтэс, сав газрын удирдлагын хэлтэстэй);
7. Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар;
8. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

б/ Батлан хамгаалах яам:

1. Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар (хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс, орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтэстэй);
2. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэс, санхүүгийн хэлтэстэй);
3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (материал хэрэгслийн хангамжийн хэлтэстэй);
4. Гадаад хамтын ажиллагааны газар;
5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

в/ Гадаад харилцааны яам:

1. Бодлого, төлөвлөлтийн газар (орчуулгын албатай);
2. Хөрш орнуудын газар;
3. Европын газар;
4. Ази, Номхон далайн орнуудын газар;
5. Америк, Ойрхи дорнод, Африкийн газар;
6. Олон талт хамтын ажиллагааны газар;

7. Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газар;

8. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэс, санхүү, эдийн засгийн хэлтэс, гадаад харилцааны төв архивтай);

9. Олон улсын гэрээ, эрх зүйн газар (хүний эрхийн хэлтэс, хилийн хэлтэстэй);

10. Консулын газар;

11. Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газар;

12. Дипломат ёслолын газар;

13. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

г/ Сангийн яам:

1. Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар (төсвийн нэгтгэлийн хэлтэс, төсвийн орлогын хэлтэс, төсвийн зарлагын хэлтэстэй);

2. Эдийн засгийн бодлогын газар (макро эдийн засгийн бодлогын хэлтэс, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэстэй);

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар;

4. Санхүүгийн бодлогын газар (санхүүгийн зах зээл, даатгалын хэлтэс, санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтэс, өрийн удирдлагын хэлтэстэй);

5. Төсвийн хөрөнгө оруулалтын газар;

6. Хөгжлийн санхүүжилтийн газар (зээл, тусламжийн бодлогын хэлтэстэй);

7. Төрийн захиргааны удирдлагын газар (санхүүгийн мэдээллийн технологийн хэлтэс, санхүүгийн хэлтэстэй);

8. Төрийн сангийн газар (санхүүжилт, тайлан, бүртгэлийн хэлтэс, төлбөр, тооцооны хэлтэстэй);

9. Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар (дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, санхүүгийн хяналт, шалгалтын хэлтэстэй);

10. Хууль, эрх зүйн газар (худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэстэй).

д/ Хууль зүй, дотоод хэргийн яам:

1. Хууль зүйн бодлогын газар (захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтэстэй);



2. Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газар;

3. Төрийн захиргааны удирдлагын газар (санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэстэй);

4. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

е/ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам:

1. Бодлого, төлөвлөлтийн газар (хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэлтэс, нийгмийн хамгааллын бодлогын хэлтэс, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэстэй);

2. Хүн амын хөгжлийн газар (хүүхэд, залуучууд, ахмад настан, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтэс, жендэрийн үндэсний хорооны ажлын албатай);

3. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэс, санхүүгийн хэлтэс, гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй);

4. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтэстэй);

5. Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэстэй);

6. Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (нийгмийн даатгалын хэлтэс, нийгмийн халамжийн хэлтэстэй);

7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

ж/ Барилга, хот байгуулалтын яам:

1. Бодлого, төлөвлөлтийн газар (үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хэлтэс, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс, норм, нормативын хэлтэстэй);

2. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэс, санхүүгийн хэлтэстэй);

3. Хот байгуулалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

4. Барилга, нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

5. Барилгын чанар, аюулгүй ажиллагааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.



з/ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам:

1. Боловсролын бодлогын газар (сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтэс, суурь, бүрэн дунд боловсролын хэлтэс, дээд боловсролын хэлтэстэй);

2. Шинжлэх ухаан, технологийн бодлогын газар (инноваци, өндөр технологийн хэлтэстэй);

3. Соёл, урлагийн бодлогын газар;

4. Биеийн тамир, спортын бодлогын газар;

5. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэс, гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй);

6. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

7. Санхүү, эдийн засгийн газар (хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэстэй);

8. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

и/ Зам, тээврийн хөгжлийн яам:

1. Бодлого, төлөвлөлтийн газар (хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс, стандарт, нормативын хэлтэстэй);

2. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэс, гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй);

3. Авто зам, авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (замын ашиглалт, засварын хэлтэстэй);

4. Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (далайн ашиглалт, усан замын тээврийн хэлтэстэй);

5. Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс;

6. Хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (зам, тээврийн хяналтын хэлтэстэй).

к/ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам:

1. Уул уурхайн бодлогын газар;

2. Геологийн бодлогын газар;

3. Түлшний бодлогын газар;

4. Хүнд үйлдвэрийн бодлогын газар (техник, технологийн хэлтэс, металл бус үйлдвэрлэлийн хэлтэстэй);



5. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэс, гадаад хамтын ажиллагааны хэлтэс, санхүүгийн хэлтэстэй);

6. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

л/ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам:

1. Бодлого, төлөвлөлтийн газар (санхүү, эдийн засгийн хэлтэс, хуулийн хэлтэстэй);

2. Төрийн захиргааны удирдлагын газар (гадаад хамтын ажиллагааны хэлтэстэй);

3. Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

4. Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

5. Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

6. Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

7. Жижиг, дунд үйлдвэр, дотоод худалдаа, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

8. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

м/ Эрчим хүчний яам:

1. Бодлого, төлөвлөлтийн газар (хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэстэй);

2. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэс, санхүүгийн хэлтэстэй);

3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (эрчим хүчний хэлтэс, сэргээгдэх эрчим хүчний хэлтэс, түлшний (эрчим хүчний нүүрс) хэлтэстэй);

4. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

н/ Эрүүл мэндийн яам:

1. Бодлого, төлөвлөлтийн газар (хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэстэй);

2. Төрийн захиргааны удирдлагын газар (хуулийн хэлтэс, гадаад хамтын ажиллагааны хэлтэс, санхүүгийн хэлтэстэй);

3. Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

4. Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

5. Эрүүл мэндийн технологийн газар;

6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар.

2. Яамдын орон тооны хязгаарыг хавсралт ёсоор баталсугай.

3. Яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төслийг боловсруулан 2016 оны 8 дугаар сард багтаан Засгийн газарт оруулахыг сайд нарт даалгасугай.

4. Яамны газар, хэлтэс, нэгж нь орлогч даргагүй, нэгжүүд болон ажилтнууд нь чиг үүргийн давхардалгүй байхаар яамны үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 382 дугаар тогтоол, “Төрийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 5 дугаар тогтоол, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 157 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ж.МӨНХБАТ

Засгийн газрын 2016 оны 3 дугаар
тогтоолын хавсралт

ЯАМДЫН ОРОН ТООНЫ ХЯЗГААР

№	Яамны нэр	Орон тооны хязгаар
1.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	121
2.	Батлан хамгаалах яам	60
3.	Гадаад харилцааны яам	142



4.	Сангийн яам	145
5.	Хууль зүй, дотоод хэргийн яам	108
6.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	117
7.	Барилга, хот байгуулалтын яам	69
8.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	106
9.	Зам, тээврийн хөгжлийн яам	145
10.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	78
11.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	101
12.	Эрчим хүчний яам	95
13.	Эрүүл мэндийн яам	100

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.0

Индекс: 14003